

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2017 ОНЫ ХОРИНГУРАВДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2017 оны арваннэгдүгээр сарын 02-ны 14 цаг 10 минутад эхэлж, 14 цаг 56 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д 46 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах Комиссын танилцуулга /Удирдах албан тушаалд томилогдох нээлттэй сонгон шалгаруулалтын дүн, тайлан/	
2	УИХ-ын Тамгын газрын Захиргаа, санхүү, үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон шалгаруулах комиссын Д/55 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн: Луулайн Хосбаярыг Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, санхүү үйлчилгээний хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга /Ц.Цолмон/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.
3	УИХ-ын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14 дүгээр зүйлийн “а”, Сонгон

		<p>шалгаруулах комиссын Д/56 дугаар дүгнэлт, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>Загдсүрэнгийн Нямцогтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга /Ц.Цолмон/-д санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
4	<p>Сэлэнгэ, Төв аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо нөхөх мэргэшлийн шалгалтын дүн</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйл, Төв аймаг дахь Салбар зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 207 тоот албан бичиг, төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 23 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 30 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын</p>

	<p>төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс гуравдугаар хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 5 иргэн, "Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц"-д бүртгэгдсэн иргэдээс дөрөвдүгээр хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 10 иргэн, нийт 15 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Тогтоолын хоёрт дурдсан нэр бүхий 15 иргэнийг "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь Салбар зөвлөл /Ч.Сарангэрэл /-д үүрэг болгох</p> <p>4. Тогтоолын биелэлтэд хяналт тавих, ажлын байрны сул орон тоог цахим хуудсаар олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй мэдээлэх, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамбад даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"-ын 8 дугаар зүйл, Сэлэнгэ аймаг дахь</p>
--	--

		<p>Салбар зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 17 дугаар тогтоол, төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн:</p> <p>1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 38 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 55 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс гуравдугаар хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 6 иргэн, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс дөрөвдүгээр хавсралтад дурдсан хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 12 иргэн, нийт 18 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх</p> <p>3. Тогтоолын хоёрт дурдсан нэр бүхий 18 иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг</p>
--	--	---

		<p>баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөл /Ө.Сувдаа/-д үүрэг болгох</p> <p>4. Тогтоолын биелэлтэд хяналт тавих, ажлын байрны сул орон тоог цахим хуудсаар олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй мэдээлэх, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамбад даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гарахаар тогтов.</p>
--	--	--

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
АЖЛЫН АЛБА**